



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/518.

Булган сум

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг
дэмжих тоног төхөөрөмжийг хүлээн авах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/192 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тоног төхөөрөмж (Улсын хэмжээнд)" төсөл, арга хэмжээний багц-3 "Булган аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж нийлүүлэх" УТ2501900343003/06-451 дугаар гэрээний дагуу гүйцэтгэгч "Урансархиа" ХХК-иас нийлүүлж байгаа 493,116,169 (дөрвөн зуун ерэн гурван сая нэг зуун арван зургаан мянга нэг зуун жаран ес) төгрөгийн үнэ бүхий жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Г.Гантулга (Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Н.Пүрэвсайхан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
Г.Ганхуяг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн хэлтсийн ахлах мэргэжилтэн "Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн дарга")
Д.Уламбаяр (Орон нутгийн өмчийн газрын Бүртгэл ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Д.Мөнхбаасан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга)

2. Ажлын хэсэг нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмжийн иж бүрдлийг бүрэн бүтэн, ашиглалтын бэлэн байдлыг хянаж, холбогдох баримт бичгийг бүрдүүлж, техникийн тодорхойлолтод заасны дагуу хүлээн авах, зохиж журмын дагуу холбогдох байгууллагад шилжүүлэн өгөхийг ажлын хэсэг (Г.Гантулга)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Сугаг Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010918